

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2017 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн
А-1/1295 дугаартай албан бичгийн хавсралт

"ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ"-нд ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
(2017 оны эхний хагас жилийн ажлын явц)

2017.05.24

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Үнэлгээ, хувиар	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн явцын талаарх мэдээлэл	Хэрэгжилтэд учирч буй бэрхшээл	Биелэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлууд	Цаашид шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээ
<p>СТРАТЕГИ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ БОГИНО ХУГАЦААНД САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ: 1.1. Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ. АРГА ХЭМЖЭЭ: 1.1.7. Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг сайжруулах.</p>							
<p>1.1.7.5. Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасны дагуу стратегийн орд газар эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах ажиллагааг эрчимжүүлэх</p>	<p>Стратегийн орд газар эзэмшигч компаниудын хувьцааг биржид арилжаалж эхэлсэн байх</p>	<p>2</p>	<p>"Үнэлэх боломжгүй", бэлтгэл ажил хийгдэж байгаа.</p>	<p>Энэхүү арга хэмжээг "Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө"-нд 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. "Шивээ-Овоо" ХК-ийн 39 хувийн хувьцааг, "Багануур" ХК-ийн 24 хувийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр арилжаалсан байхаар УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн 4.8, 4.9-д тус тус тусгагдсан. Төрийн өмчийг 2017-2018 онд хувьчлах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлах хүртэл төрийн өмчийг хувьчлах ажлыг дээр дурдсан үндсэн чиглэлийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулахаар 2016 оны УИХ-ын 64 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн боловч хэрэгжээгүй.</p>	<p>Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-д зааснаар "Шивээ-Овоо" ХК, "Багануур" ХК нь "Эрдэнэс Монгол" ХХК-д харьяалагдаж байгаа бөгөөд "Эрдэнэс Монгол" ХХК-д төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар хариуцдаг. Иймээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дурдсан компаниудад төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлдэггүй болно. "Эрдэнэс Монгол" ХХК нь дээр дурдсан 2 ХК-тай холбоотой хувьчлалын асуудлаарх хэрэгжилтийн мэдээллийг ТӨБЗГ азарт өгөөгүй байна. Цаашид хувьчлалын асуудлыг хэрхэх талаар санал авахаар ТӨБЗГ-аас "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-д албан бичиг хүргүүлсэн боловч саналаа мөн ирүүлээгүй байна.</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас "Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн төслийг боловсруулаад байна. Энд дурдсан 2 ХК-ийн асуудлыг уг үндсэн чиглэлийн төсөлд тусгах эсэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас санал авсан. <u>УУХҮЯ-ны санал:</u> "Шивээ-Овоо" ХК, "Багануур" ХК-ийн тус бүрийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар тэдгээр компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төсөл хэрэгжүүлнэ" гэж санал өгсөн.</p>	<p>"Шивээ-Овоо" ХК, "Багануур" ХК-ийн тус бүрийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих талаар "Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн төсөлд тусган боловсруулж, төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт болон УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлээд байна.</p>

<p>1.1.7.6. Төрийн өмчит хувьцаат компаниудын хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулах, зохицуулалтын бодлогоор дэмжиж ажиллах</p>	<p>Үнэт цаасны арилжааны хэмжээ, зах зээлийн үнэлгээ нэмэгдүүлэх, хувиар</p>	<p>5 ба түүнээс дээш</p>	<p>Үнэлэх боломжгүй, бэлтгэл ажил хийгдэж байгаа.</p>	<p>Энэхүү арга хэмжээг "Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө"-нд 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Энэхүү төлөвлөгөөний 1.1.7.5 дахь заалтын хэрэгжилтэд өгүүлсэн "Шивээ-Овоо" ХК, "Багануур" ХК-аас гадна "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг хувьчлах тухай заалтыг "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-д нэмж тусгахаар УИХ-ын 2015 оны 102 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. Одоогоор хувьцааг арилжиж эхлээгүй байна.</p>	<p>УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл" нь УИХ-ын 2016 оны 64 дүгээр тогтоолд зааснаар одоо хүчин төгөлдөр үргэлжилж байгаа бөгөөд биелэлт нь 20 хувьтай буюу хэрэгжилт нь гадаад, дотоод хүчин зүйлээс шалтгаалж удааширсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас "Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн төсөлд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн талаарх асуудлыг хэрхэн тусгах талаар Сангийн яамнаас санал авахаар ТӨБЗГ-ын 2017-01-31-ний өдрийн 1/183 дугаар албан бичгээр хандсан боловч санал ирүүлээгүй байна. (Сангийн яам нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д төлөөлөл хэрэгжүүлдэг)</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас "Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн төслийг боловсруулж, саналаа ЗГХЭГ-т хүргүүлээд байна. Уг үндсэн чиглэлд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн талаарх асуудлыг тусгах арга хэмжээ авсан.</p>	<p>"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн зах зээлийн үнэлгээг тогтоож, хувьцааны тодорхой хэсгийг Лондонгийн хөрөнгийн биржид төлөх өрөнд тооцон хувьцаагаар солих саналыг тавьж, үлдсэн хувьцааг монголын хөрөнгийн бирж болон гадаадын нэр хүнд бүхий хөрөнгийн биржээр нээлттэй арилжих талаар "Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн төсөлд тусгагдсан.</p>
---	--	--------------------------	---	--	--	--	---

Хянасан:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН В.ДАРХАНБААТАР

Боловсруулсан:
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ